

2025 ОНЫ 1 ДҮГЭЭР САР

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХАЛАМЖИЙН ЗАРДАЛ БА СОНГУУЛЬ

Монгол Улсын Нийгмийн халамжийн бие даасан хуулийг УИХ-аас 1995 онд анх баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Уг хуульд “Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ” гэж заасан байдаг.

Манай улсад нийгмийн халамжийн бодлогын хүрээнд нийт 12 багцын 70 гаруй хөтөлбөр хэрэгжиж байна. Тэдгээр нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, иргэнд наад захын хэрэгцээг нь хангах, тэдгээрийг хамгаалах, ядуурал, ажилгүйдлийг бууруулах зорилготой. Гэвч бодит байдал дээр халамжийн хөтөлбөрүүд нь үндсэн зорилгоосоо хазайн нийтлэг шинжтэй болж байгааг шүүмжлэх хандлага олон нийтийн дунд нэмэгдэж байна. Иймд бид халамжийн зардал ба УИХ-ын сонгуулийн жилийн хоорондын харилцан хамаарлыг шинжиллээ.

УДИРТГАЛ

Нийгмийн халамжийн сангийн зардал¹ 2012 онд 225 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 2.1 их наяд төгрөг болж 12 жилийн хугацаанд 9 дахин, жилд дунджаар 28.4 хувиар өсжээ. Харин нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын тоо давхардсан байдлаар 2012 онд 1.5 сая байсан бол 2023 онд 2.7 сая болж өссөн нь нийт хүн амын 77 хувьтай тэнцэж байна. Харин Нийгмийн халамжийн сангийн нийт зардалд хүүхдийн мөнгөн тэтгэмж (ХМТ)-ийн эзэлж буй хувь 2012 онд 23.67 хувь байсан бол 2023 оны байдлаар 71.5 хувь болж дийлэнх хэсгийг бүрдүүлсэн.

Энэхүү дүн шинжилгээнд халамжийн зардал² ба

УИХ-ын сонгуулийн жилийн хоорондын харилцан хамаарлыг дүгнэн шинжлэв.


НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЗАРДАЛ БА СОНГУУЛИЙН ЖИЛИЙН ХАМААРАЛ

2012 онд Монгол Улсын төсвийн 3.7 хувийг эзэлдэг байсан нийгмийн халамжийн зардал 2023 оны байдлаар 9.4 хувьд хүрээд байна. Гэсэн хэдий ч нийгмийн халамжийн зардлын өсөлт нь цаг хугацааны хувьд жигд биш байна. Тухайлбал, сүүлийн 12 жилийн хугацаанд сонгуулийн дараагийн жил нийгмийн халамжийн зардлын төсөвт эзлэх хувь дунджаар 2 хувиар өсөж байгаа бол бусад хугацааны дундаж өсөлт нь 0 хувь байна.

1. Дараах зардалд 2012-2016 оны хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардлыг нэмж тохируулсан болно.

2. Энэхүү дүн шинжилгээн дэх халамжийн зардлын дүнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардал орсон болно.

График 1. Төсвийн нийт зардалд халамжийн зардлын эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2012-2023 он)


Нийгмийн халамжийн зардал зарим жилд эрс өсжээ. Тухайлбал, 2013 онд төсвийн зардалд халамжийн зардлын эзлэх хэмжээ 3.7 хувиар өссөн. Энэ өсөлтийн гол шалтгаан 2012 оны 10 дугаар сараас эхлэн Монгол Улсын хүүхэд бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгож эхэлсэн ба мөн 2013 оны 6 дугаар сараас цаатан иргэдийн тэтгэмжийг олгож эхэлсэн явдал юм. 2017 онд төсвийн зардалд халамжийн зардлын эзлэх хэмжээ 1.1 хувиар өссөнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрагдалтын хувийг нэмэгдүүлсэн бөгөөд 2018 оноос хэрэгжих “Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай” хуулийн төсөл батлагдсан нь нөлөөлсөн. 2020 онд төсвийн зардалд халамжийн зардлын эзлэх хэмжээ 5.7 хувиар өссөн нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр үүссэн цочролын эрсдэлийг бууруулах, өрх айлын амьжиргааг дэмжих чиглэлээр хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж ба хүнсний эрхийн бичгийн мөнгөн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой. Цаашилбал, 2021 онд төсвийн зардалд

халамжийн зардлын эзлэх хэмжээ 1.2 хувиар өссөнд цар тахлын үеийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэрийн дагуу нэмэгдсэн дүнгээр олгосон нь нөлөөлсөн юм.

2012 оноос хойш хүүхдийн мөнгөн тэтгэмжээс бусад халамж авагчдын нийт тоо 2.5 дахин өссөн. Нийгмийн халамж авагчдын тоо нэмэгдэж байгаа хэдий ч төсөвт эзлэх зардлын хувь 2.7-4.4 хувийн хооронд хэлбэлзэж байна. 2013 болон 2017 онуудад ХМТ-ийг хассан халамжийн зардлын төсөвт эзлэх хувь нийт 1.4 хувиар, халамж авагчдын нийт хүн амд эзлэх хувь 12.3 хувиар тус тус нэмэгдсэн байна. Энэ нь тухайн жилд хэрэгжүүлсэн “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг бүх хүүхдэд олгох”, “Хүнсний эрхийн бичиг”, “Насны хишиг”, “Цалинтай ээж” зэрэг шинэ хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой.


Уг зардлын эзлэх хувь буурах хандлага ажиглагдаж байгаа бөгөөд үүний шалтгаан нь хөтөлбөрт олгож буй тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ жил бүр тогтмол нэмэгддэггүйтэй холбоотой юм.

График 2. Улсын төсөвт халамжийн зардлын эзлэх хувь хэмжээ (Хүүхдийн мөнгөн тэтгэмж ороогүй дүн)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2024 он

График 3. Нийт хүн амд халамж авагсдын эзлэх хувь хэмжээ (Хүүхдийн мөнгөн тэтгэмж ороогүй дүн)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2024 он

Нийт халамж авагчдын тоо давхардсан тоогоор 2012 онд 1.5 сая байсан бол 2024 онд 2.7 сая болон 1.8 дахин нэмэгдсэн байна. Эдгээрийн 50 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж авагчид буюу хүүхдүүд бүрдүүлдэг.

Хүүхдийн тоог хассан халамж авагчдын тоо давхардсан тоогоор 2012 онд 556 мянган байсан бол 2024 онд 1.4 сая болон 2.5 дахин өссөн байна. Эдгээрийн нийт хүн амд эзлэх хувь 2012 онд 20.1 хувь байсан бол 2024 онд 40.6 хувь болж нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтийг хугацаагаар тодруулан харвал, 2013 онд өмнө оноос 6.4 функтаар, 2016 онд өмнө оноос 6.8 функтаар, 2017 онд өмнө оноос 6.9 функтаар тус тус өссөн бол 2021 онд өмнө оноос 4.2 функтаар буурсан байна. 2013 оны өсөлт


нь нийгмийн хөгжлийн үйлчилгээний хүрээнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ буюу Хүнсний эрхийн бичгийг олгох болсноор 100 мянган иргэнд олгож эхэлжээ. 2016 болон 2017 оны өсөлт нь “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж”-ийн хүрээнд “Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж”-ийн хамрагдалт, “Насны хишиг”, “Цалинтай ээж” зэрэг шинэ хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна.

Харин 2020 оны сонгуулийн жилээс хойш нийт хүн амд эзэлж буй халамж авагчдын тоо буурах хандлагатай байна. Энэ нь 2021 оноос хойш халамжийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлээгүй, хуучин хөтөлбөрүүдийн дүнг нэмэгдүүлэх ажлууд хийгдсэнтэй холбоотой гэж үзэж байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ БА СОНГУУЛИЙН ЖИЛ

Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг баталсан болон хуульд өөрчлөлт оруулсан хугацаа нь УИХ-ын сонгуулийн хугацаатай хамааралтай байгаа эсэхийг энэ хэсэгт шинжлэв.

График 4. 2012–2024 оны халамжийн нийт зардлын хэмжээ ба ХМТ ороогүй дүн (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2024 он

2012-2024 оны нийгмийн халамжийн зардлын өөрчлөлтийг ажиглахад, 2012-2018 онд нийт зардал тогтвортой, харьцангуй бага өсөлттэй байсан ч 2019 оноос эхлэн огцом нэмэгдсэн харагдаж байна. Уг өсөлтөд хүүхдийн мөнгөний хөтөлбөрийн

санхүүжилт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн. ХМТ-ийг хассан нийгмийн халамжийн зардлын дундаж өсөлтийн хувь 15.4 хувь байгаа бол ХМТ-ийг оруулж тооцсон нийт зардлын дүнгийн өсөлтийн хувь 25.6 хувь байна.

График 5. 2012–2024 оны халамжийн 12 төрлийн зардлын дүн (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2024 он

Нийгмийн халамжийн нийт зардлын нийт дүн 2012 онд 225.04 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 2,414.23 тэрбум төгрөг болж 10 дахин өссөн үзүүлэлттэй байна. Зардлын бүтцийг ангилан харвал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, эх, олон хүүхэдтэй

болон өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж зэрэг нь нийт зардлын 85.7 хувийг эзэлж, голлох байр суурьтай байгаа бол үлдсэн 8 төрлийн тэтгэмж нь 14.3 хувийг эзэлж байгаа нь халамжийн санхүүжилт тодорхой төрлүүдэд төвлөрч буйг илтгэж байна.

ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- 2012-2013 оны хооронд халамжийн зардал мөнгөн дүнгээр 4 дахин нэмэгдсэн нь 2012 оны 10 сараас эхлэн Монгол Улсын хүүхэд бүрд 20,000 төгрөг олгох болсонтой холбоотой юм. Түүнээс өмнө амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдэд уг мөнгөн тэтгэмжийг олгож ирсэн. 2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгох амлалт өгсөн нь Засгийн газрын бодлого болж хэрэгжсэн.
- 2020 онд хүүхдийн мөнгөн тэтгэмж мөн өмнөх оноос 5 дахин өссөн нь Ковид-19 цар тахлаас улбаалан хүүхэд бүрд олгож байсан мөнгөн дүнг 100,000 төгрөг болгон нэмэгдүүлсэнтэй холбоотой. Энэ нэмэгдэл нь цар тахлын үед олон өрхийн санхүүгийн хүндрэлтэй байдлыг хөнгөвчлөх зорилготой байсан бөгөөд энэ шийдвэр нь тэтгэмжийн зардлыг огцом өсгөсөн.
- 2022 оноос хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100,000 төгрөг болгон нэмэгдүүлснийг хэвээр үлдээж, цаашид тогтмол олгох Засгийн газрын шийдвэр гарсан.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВРИЙН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- 2020 онд нийгмийн халамжийн тэтгэврийн зардал ойролцоогоор 50 хувиар нэмэгдсэн бөгөөд үүнд 2020 оны 1 дүгээр сард халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг 188,000 төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой. Мөн тухайн жилд УИХ-аас “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийг баталсан билээ.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖИЙН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын тогтоолоор Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 325,000 төгрөгөөр, асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 275,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон.

АЛДАР ЦОЛТОН АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛСЭН НЭМЭГДЭЛ, УРАМШУУЛАЛ

- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Боловсрол, шинжлэх ухаан, спортын салбарын алдар олтон ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад батлагдсан ба энэхүү өөрчлөлттэй холбоотой 2021 оноос энэхүү зардал буурсан байна.

ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦГИЙН ТЭТГЭМЖ

- Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль 2017 оны 6 дугаар сарын 30-нд батлагдсан ба 2018 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуулийн хүрээнд жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж авахаар болсон ба Засгийн газрын 2017 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд тэтгэмжийн хэмжээг сард 50,000 төгрөг байхаар тогтоосонтой холбоотой зардлын хэмжээ өссөн байна.

ЦААТАН ИРГЭНИЙ ТЭТГЭМЖ

- Засгийн газрын 2013 оны 168 дугаар тогтоолд тайгад амьдардаг цаатан иргэнд Хангайн бүс нутгийн хүн амын амьжиргааны доод түвшин, хүүхдэд түүний 50 хувьтай тэнцэх хэмжээгээр сар бүр мөнгөн тэтгэмжийг олгох арга хэмжээг 2013 оны 6 дугаар сараас 2018 оны 6 дугаар сар хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хуучнаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/72 дугаар тушаалаар “Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам”-ыг баталсан. Энэхүү шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой зардлын хэмжээ өссөн.

Нийгмийн халамжийн зардлын хэмжээнээс гадна тухайн 12 төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээг авч буй иргэдийн тоог авч үзэхэд нийгмийн хөгжлийн үйлчилгээг авч буй иргэдийн тоо 2017 онд 82 хувиар өссөн байна. Энэ нь зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд хэрэгжиж буй 70 гаруй хөтөлбөрт орсон өөрчлөлт, шинэчлэлтийг сонгуультай уялдуулан шинжлэх зорилгоор тодорхой хугацаагаар харьцуулалт хийв. Тухайлбал, сонгуультай ойрхон 2-3 сарын хугацаанд, сонгуулийн өмнөх 1 жилийн хугацаанд, мөн сонгуулийн дараах 1 жилийн хугацаанд Нийгмийн халамжийн тухай хууль, бодлого, хөтөлбөрүүдэд орсон өөрчлөлтүүдийг тус тус харьцуулан дор дүгнэлээ.

Хүснэгт 1. Нийгмийн халамжийн тухай хууль, бодлого зохицуулалтад орсон өөрчлөлтийн цаг хугацаа

Сонгуультай ойрхон 2-3 сарын дотор өөрчлөгдсөн бодлогын баримт бичгийн тоо	Сонгуулийн өмнөх 1 жилийн дотор өөрчлөгдсөн бодлогын баримт бичгийн тоо	Сонгуулийн дараа 1 жилийн дотор өөрчлөгдсөн бодлогын баримт бичгийн тоо
37 хөтөлбөрийг УИХ-ын сонгуультай ойрхон 2-3 сарын дотор шинэчлэн баталж өөрчлөлт оруулж байжээ.	12 (2-3 сарын дотор өөрчлөгдсөн баримт бичгүүдийг хассан) хөтөлбөрийг УИХ-ын сонгуулийн өмнөх 1 жилийн дотор шинэчлэн баталж өөрчлөлт оруулжээ.	12 хөтөлбөрийг УИХ-ын сонгуулийн дараа 1 жилийн дотор шинэчлэн баталж өөрчлөлт оруулжээ.

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем(<https://legalinfo.mn>), 2024 он

2024 оны байдлаар сонгуультай ойрхон 3 сарын хугацаанд өөрчлөлт оруулсан нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд давхардсан тоогоор 1,123,975 хүн хамрагдаж, нийт 658 тэрбум төгрөгийн зардал гарсан байна. Эдгээр өөрчлөлт орсон хөтөлбөрийг ангилан үзвэл нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих үйлчилгээ, ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж гэсэн хөтөлбөрүүд байна. Түүнчлэн, 2016, 2020 болон 2024 оны УИХ-ын сонгуулийн өмнөх 3 сарын хугацаанд эдгээр хөтөлбөрүүдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх талаар хэлэлцэн баталсан нь онцлох өөрчлөлт болжээ.

2024 оны байдлаар сонгуулийн дараах нэг жилийн хугацаанд өөрчлөлт орсон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд давхардсан тоогоор 1,679,972 хүн хамрагдаж, нийт 1.6 их наяд төгрөгийн зардал гарсан. Эдгээр өөрчлөлт орсон хөтөлбөрүүдийг ангилан харвал хүүхдийн мөнгөн тэтгэмж, алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлтөд хамаарагдах хөтөлбөрүүд, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмжид хамаарагдах хөтөлбөрүүд багтаж байна. Түүнчлэн, 2016, 2020 оны УИХ-ын сонгуулийн дараах 1 жилийн хугацаанд дээрх хөтөлбөрүүдэд нэмэлт өөрчлөлт оруулан тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг өсгөх талаар хэлэлцэн баталсан байдаг.

Сонгуулиас 1 жилийн өмнөх хугацаанд өөрчлөлт орсон халамжийн хөтөлбөрүүдэд онцгой тохиолдлын тэтгэмж, цаатан иргэнд олгох тэтгэмж, эхийн алдар одонтой эхчүүдэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламж зэрэг хөтөлбөрүүд багтаж байна. Эдгээрт давхардсан тоогоор 309,049 иргэн хамрагдаж, нийт 44 тэрбум төгрөгийн зардал гаргасан бөгөөд эхийн алдар одонгийн мөнгөн тусламж дангаараа уг зардлын 80 гаруй хувийг

бүрдүүлжээ. Энэ нь сонгуулиас 1 жилийн өмнө батлагдсан халамжийн хөтөлбөрүүд хүн амын харьцангуй цөөн хэсэгт хамаарч, төсвийн зардалд үзүүлэх нөлөө бага байгааг харуулж байна.

Сонгуулийн өмнөх 1 жилийн хугацаанд батлагдаж буй хөтөлбөрүүд ихэвчлэн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх замаар нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын 40 гаруй хувьд шууд хамааралтай өөрчлөлт, шинэчлэлтийг хийсэн. Харин сонгуулийн дараах 1 жилийн хугацаанд батлагдаж буй хөтөлбөрүүд, оруулж буй өөрчлөлтүүд нь сонгуулийн амлалтыг биелүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй шинэчлэлтүүд бөгөөд эдгээр нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын 65 гаруй хувьд шууд хамааралтай байна. Тухайлбал, “Цалинтай ээж” хөтөлбөр болон “Насны хишиг” хөтөлбөр нь 2016 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаж, 2017 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд эдгээр хөтөлбөрүүд сонгуулийн дараах бодлогын өөрчлөлтийн тод жишээ болж байна.

Сонгуульд өрсөлдөж буй нам, эвслүүдийн хувьд өөрсдийн мөрийн хөтөлбөрт нийгмийн хамгааллын чиглэлээр тусгаж буй санаачилгуудыг харвал хүүхдийн мөнгөн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох, халамжийн бодлогыг зорилтот иргэдэд чиглүүлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх зэрэг байна. Эдгээрээс халамжийн бодлогыг зорилтот иргэдэд чиглүүлэх тухай заалт нь хэт ерөнхий тусгагдаж ирсэн бөгөөд бусад заалтууд нь нийгмийн халамжийн үндсэн зорилго болох “нийгмийн зүгээс зайлшгүй дэмжлэг тусалцаа шаардлагатай иргэдэд төрөөс амьдралын наад захын хэрэгцээг хангах үүднээс тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх” гэсэн зорилгод хамаарагдах эсэх нь эргэлзээтэй байна.

ДҮГНЭЛТ

Засгийн газраас 2023 оны байдлаар халамжийн бодлогын хүрээнд 12 багцын 70 гаруй хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Нийгмийн халамжийн сангийн зардал сүүлийн 12 жилийн хугацаанд 225 тэрбумаас 2.1 их наяд төгрөгт хүрж 9 дахин, халамж авагчдын тоо 1.5 саяас 2.7 сая болж 80 хувиар тус тус нэмэгдсэн. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хассан нийгмийн халамжийн зардал болон халамж авагчдын тоог харвал сонгуулийн дараагийн жил шинэ хөтөлбөр хэрэгжилттэй холбоотой нэмэгдсэн дүр зураг ажиглагдаж байна. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд олгогдож буй тэтгэвэр тэтгэмжийн дүн нь хэвээр хадгалагдсанаар халамжийн зардлын төсөвт эзлэх жин буцаад буурах хандлагатай байгаа бөгөөд ойролцоогоор 2.7-4.4 хувийн хооронд хэлбэлзэж байна. Мөн зардлын голлох өсөлт нь сонгууль болон түүний дараагийн жилүүдэд ажиглагдаж байгаа бөгөөд үүний хүрээнд баримтын шинжилгээг хийхэд дараах үр дүн гарав.

Сонгуулийн дараагийн жил төсөвт эзлэх халамжийн зардал нэмэгдэх хандлагатай байгаа нь шинэ УИХ ба Засгийн газар нь хөтөлбөрийн өөрчлөлт, шинэ хөтөлбөрийг илүү идэвхтэй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

2023 оны байдлаар халамжийн зардлын нийт төсөвт эзлэх хувь 9.4 болсон нь 2012 оноос 5.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Сонгуулийн дараагийн жилд нийгмийн халамжийн сангийн зардал дунджаар 2 хувиар нэмэгдэж байгаа нь нийт өсөлтийн ихэнх хэсгийг бүрдүүлсэн. Тухайлбал, сонгуулийн дараа бүрдсэн шинэ УИХ болон Засгийн газрын оруулсан хуулийн өөрчлөлтүүд болон шинээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь зардлын өсөлтөд голчлон нөлөөлж байна. Голлох шийдвэрүүдийг авч үзвэл 2013 онд Монгол Улсын бүх хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох, мөн цаатан иргэдийн тэтгэмж олголттой холбоотой шийдвэрүүдийг хамарч байна. Мөн 2017 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрагдалтыг нэмэгдүүлсэн бол, 2021 онд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, цаашид үргэлжлүүлэн олгохоор шийдвэрлэсэн.

Сонгуулийн дараагийн нэг жилийн хугацаанд намуудын мөрийн хөтөлбөрийн хүрээнд

дэвшүүлсэн шинэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хандлагатай байна.

Шинээр үүсгэн байгуулагдсан Засгийн газрууд үйл ажиллагааны хөтөлбөртөө намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан халамжийн шинэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар тусган, тэдгээрийг дараагийн 1 жилд хэрэгжүүлдэг нь түүхэн мэдээллээс харагдаж байна. Тухайлбал, 2012 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох, бүх хүүхдэд олгох шийдвэрийг гаргасныг дараагийн Засгийн газар хэрэгжүүлсэн бол, 2016 онд “Цалинтай ээж” хөтөлбөр болон “Насны хишиг” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Мөн 2020 онд Ковид-19 цар тахлын үеийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдлийг үргэлжлүүлэн олгох шийдвэрийг гаргасан. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй эдгээр халамжийн хөтөлбөрүүд нь нийгмийн халамжийн зорилтот бүлэгт чиглэх гэхээсээ илүүтэй нийтийг хамарсан, бүх өрхийн түвшинд олгогдох шинэ ажиглагдаж байна.

Сонгуулийн өмнө ихэвчлэн одоогийн хэрэгжиж буй нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хандлагатай байдаг.

УИХ-ын 2012-2024 оны сонгуулийн өмнө нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд голлон оруулсан өөрчлөлтүүдийг харвал нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд хийгдсэн байна. Ихэвчлэн сонгуулийн өмнөх 3-6 сарын дотор эдгээр өөрчлөлтийг оруулан, хуулийг богино хугацаанд хэрэгжиж эхлэхээр баталсан хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн дүнг 2024 оны 3 дугаар сарын 20-нд нэмэгдүүлэх шийдвэр гарган, 4 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон. Мөн Ахмад настны тухай хуулийн 12.3-т заасан насны хишгийн хэмжээг бууруулан, Засгийн газраас тухайн жилийн насны хишгийн хэмжээ, олгох журмыг баталж, тус хуулийн 7.1-д заасан ахмад настанд үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн байна. Эдгээр өөрчлөлт нь нийт халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын 40 гаруй хувьд шууд хамааралтай өөрчлөлтүүд болдог.

ХАВСРАЛТ

Монгол Улсын 2012–2024 оны халамжийн зардал (сая төгрөг)

№	Халамжийн зардлын төрлүүд	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024*
		Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	64,728	79,470	81,834	86,085	89,019	88,658	97,865	111,569	162,897	184,421	182,936	197,793	258,967
2	Нийгмийн халамжийн тэтгэмж	17,994	30,972	39,903	47,235	44,647	60,528	67,033	77,924	99,454	104,690	107,064	180,785	324,304
3	Нийгмийн халамжийн үйлчилгээ	3,470	5,234	7,198	1,797	1,656	2,378	3,722	1,877	2,025	2,299	2,964	5,037	2,854
4	Нийгмийн хөгжлийн үйлчилгээ		9,255	7,783	15,752	16,686	19,944	36,229	35,810	55,452	30,966	19,958	15,545	26,262
5	Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	28,938	28,556	28,420	28,360	28,256	28,788	28,940	29,291	29,775	30,466	31,009	31,486	30,694
6	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	53,264	228,994	238,432	246,000	218,842	257,653	209,020	229,592	1,053,046	1,454,704	1,484,988	1,520,097	1,562,862
7	Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	12,702	14,158	19,154	21,408	24,236	25,006	30,132	30,206	28,510	16,937	25,984	28,490	25,520
8	Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	5,127	5,109	4,966	4,964	4,700	4,616	5,128	5,164	5,142	442	686	795	7,460
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	6,082	7,477	9,278	9,091	9,690	9,575	11,064	11,496	10,836	9,297	9,639	11,661	9,652
10	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	32,614	45,719	39,971	40,971	38,831	37,052	112,699	115,468	116,282	114,675	108,786	105,868	131,714
11	Насны хишиг						19,836	20,554	21,755	22,754	24,029	25,063	26,662	24,945
12	Цаатан иргэний тэтгэмж	118	672	685	1,002	557	600	565	656	746	805	858	1,024	9,000
	Нийт зардлын хэмжээ	225,036	455,618	477,623	502,665	477,117	554,635	622,950	670,809	1,586,918	1,973,730	1,999,935	2,125,244	2,414,233

Боловсруулсан: Д.Болортуяа,
Ц.Булгансайхан
Дугаарыг эрхэлсэн: Д.Оюунбадам,
Нээлттэй нийгэм
форумын
Засаглалын
хөтөлбөрийн
менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn